



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 739.

Улаанбаатар хот

Автомашины тоо, төрөл тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 5 дугаар заалт, Монгол улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 95/260 дугаар тушаалаар баталсан "Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам"-ын 3.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Үндэсний статистикийн хорооны үйл ажиллагааны онцлог, цар хүрээг харгалзан Үндэсний статистикийн хороо, харьяа байгууллагын үндсэн үйл ажиллагаа, дотоод албан хэрэгцээнд ашиглах үйлчилгээний автомашины тоо, төрлийг хавсралтад зааснаар баталсугай.

2.Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын дарга Б.Лхагвад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үйлчилгээний автомашин ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах;

2.2.Албан хэрэгцээнээс илүү гарсан, үйл ажиллагааны онцлог, хэрэгцээ шаардлага хангахгүй байгаа автомашиныг данснаас хасах, хэрэгцээт байгууллагад шилжүүлэх саналаа ирүүлэх;

2.3.Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журмын хэрэгжилтийг хангах;

2.4.Арга хэмжээний биелэлтийн хамт 2025 оны 1 дүгээр улиралд багтаан тайлагнах.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132003117
31-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2024 оны 12 дугаар сарын 16 өдрийн
 789 дугаар тогтоолын хавсралт



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО БОЛОН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН
 ДОТООД АЛБАН АЖЛЫН ХЭРЭГЦЭЭНД АШИГЛАХ АВТОМАШИНЫ АНГИЛАЛ,
 ТОО, ТӨРӨЛ

Д/д	Байгууллагын нэр	Үндсэн ангилал	Төрөл	Тоо
1	Үндэсний статистикийн хороо	Үйлчилгээний автомашин	Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/	1
			Хот доторх ажлын суудлын автомашин /жижиг/	1
2	Архангай аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс		Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/	1
3	Баян-Өлгий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс		Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/	1
4	Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс		Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/	1
5	Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс		Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/	1
6	Говь-Алтай аймгийн Засаг даргын дэргэдэх статистик		Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/	1
7	Дорноговь аймгийн Засаг даргын дэргэдэх статистик		Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/ 07-14ДГО	1
8	Дорнод аймгийн Засаг даргын дэргэдэх статистик		Суудлын автомашин /жижиг/	1
9	Дундговь аймгийн Засаг даргын дэргэдэх статистик		Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/	1

Д/д	Байгууллагын нэр	Үндсэн ангилал	Төрөл	Тоо
10	Завхан аймгийн Засаг даргын дэргэдэх статистик	Үйлчилгээний автомашин	Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/ 01-483АН	1
11	Өвөрхангай аймгийн Засаг даргын дэргэдэх статистик		Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/ 62-10ӨВА	1
12	Өмнөговь аймгийн Засаг даргын дэргэдэх статистик		Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/	1
13	Сүхбаатар аймгийн Засаг даргын дэргэдэх статистик		Суудлын автомашин /жижиг/	1
14	Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх статистик		Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/	1
15	Төв аймгийн Засаг даргын дэргэдэх статистик	Үйлчилгээний автомашин	Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/	1
16	Увс аймгийн Засаг даргын дэргэдэх статистик		Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/ 5028УВХ	1
17	Ховд аймгийн Засаг даргын дэргэдэх статистик		Суудлын автомашин /жижиг/	1
18	Хөвсгөл аймгийн Засаг даргын дэргэдэх статистик	Үйлчилгээний автомашин	Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/	1
19	Хэнтий аймгийн Засаг даргын дэргэдэх статистик		Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/	1
20	Дархан аймгийн Засаг даргын дэргэдэх статистик		Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/ 75-47ДАХ	1
21	Орхон аймгийн Засаг даргын дэргэдэх статистик		Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/	1
22	Говьсүмбэр аймгийн Засаг даргын дэргэдэх статистик		Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/	1
Нийт автомашин				23

